



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/97/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Б.Алтанзул Утас: 70523020 Цахим хаяг: altanzulb@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гуламж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.28 № 1-6/139

танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Б.РАГЧААСҮРЭН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР _____ Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	5.5	3.4
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4.5	4.2
Нийт хөрөнгийн дүн	10.0	7.5
Нийт өр төлбөрийн дүн	3.1	0.2
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6.9	7.3
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10.0	7.5
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	61.5	67.3
Үйл ажиллагааны зардлын дүн	61.2	67.7
Үйл ажиллагааны үр дүн	0.3	0.4
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-0.3
Үйл ажиллагааны нийт үр дүн	0.3	-0.7
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	61.5	67.1
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	59.0	66.5
Үйл ажиллагааны ЦМГ	2.5	0.6
Хөрөнгө оруулалтын ЦМГ	2.5	0.6
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6.7	8.0
Тайлант оны үр дүн	0.3	0.7
Эцсийн үлдэгдэл	7.0	7.3
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	60.3	59.8
Урсгал зардал	60.3	59.8
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	60.3	59.8
Орон нутгийн төсвөөс санхүүжих	60.3	59.8
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрхэм зорилго:

Нутгийн иргэдийн идэвхи оролцоонд тулгуурлан орон нутгийн болон иргэдийн өмнө тулгамдсан асуудлыг хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэж, иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах нөхцлийг хангана.

Хөвсгөл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Хурлын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах;

- Тухайн Хурлын хороог байгуулах, хорооны бүрэлдэхүүн, даргыг сонгох, өөрчлөх;
- Тухайн шатны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх;
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд хугацааны бодлого, жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах;
- Хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох;
- Орон нутгийн өмчийн зүйлсийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх
- Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх Засаг даргын үйл ажиллагаанд хяналт тавих;
- Худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам батлах;

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системд өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 5.8 сая төгрөгийн 12 тушаалыг мэдээлээгүй байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар илэрсэн 1 алдаа зөрчилд албан шаардлага өгсөн.

Албан шаардлага

1. Шилэн дансны системд өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 5.8 сая төгрөгийн 12 тушаалыг мэдээлээгүй байна. Энэ нь “Шилэн дансны тухай” хуулийн 6.4.8-т “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ								

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	1	0	0	0	0	0	1	0	0	0
	НИЙТ	1	0	0	0	0	0	1	0	0	0